BSKY
BLUE SKY
SECURITIES

# "БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр сарын 04 №22/03/01 Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, болон санхүүгийн тайлан, төсөлийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ :**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсугай.
3. Төлөөлөн Удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх төслийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Г.ОЮУНБОЛД**

BSKY
BLUE SKY SECURITIES

# "БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр сарын 04 № 22/03/03 Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлүүд, 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрхийг нэмж авч байгаа тул холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
4. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Г.ОЮУНБОЛД**

BSKY
BLUE SKY SECURITIES

# "БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр сарын 04 №22/01/02 Улаанбаатар хот

**Компани ногдол ашиг хувиарлахгүй тухай**

**1.** Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсаныг мэдэгдсүгэй.

**ХУРЛЫН ДАРГА** **Г.ОЮУНБОЛД**

BSKY
BLUE SKY SECURITIES

# "БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр сарын 04 № 22/03/04 Улаанбаатар хот

**Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76, 89, 92- р зүйлүүд, 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь цаашид Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрхийг нэмж авах гэж байгаатай холбогдуулан гадаад арилжааны платформ, Back office систем, IOS болон Android гар утасны аппликэйшнуудыг хийх чадамжтай хувь хүн, хуулийн этгээдүүдийг шалгаруулан тэдэнтэй их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Уг хэлцэл болон сонгон шалгаруулалтанд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА** **Г.ОЮУНБОЛД**